

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛ /Аудитлагдаагүй, Монголбанк суурьтай/

2023 оны 10 сарын 9



САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ /01'2023-09'2023/

2023 оны эхээр коронавируст цар тахлын дараа Хятад улстай хил нээгдсэнээр манай улсын нүүрсний экспорт сэргэж, худалдааны тэнцэл ашигтай гарав. Валютын нөөц сэргэж, ханш тогтворжин, Монгол Улсын эдийн засаг сэргэж эхэллээ. Энэ хооронд инфляцын түвшин буурч байгаа ч хоёр оронтой тоонд хэвээр байна. Монгол Улсын Төв банк бодлогын хүүгээ өндөр түвшинд буюу 13 хувьд барьж байна.

Энэ хугацаанд банкны харилцагчийн эх үүсвэр 20%, зээл 14%-р тус тус өсөж, төсөвлөсөн хэмжээнээс давав. Банкны салбарын зах зээлд эзлэх хувь* эх үүсвэрийн хэмжээгээр 19.7%, зээлийн хэмжээгээр 16.3%-д тус тус хүрэв.


Зах зээл дээр хүүгийн түвшин өндөр байгаатай холбоотой 2023 оны 3-р улирлын эцсийн байдлаар хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 47%-р, цэвэр хүүгийн орлого 28%-р өсөж 334.8 тэрбум төгрөгт хүрлээ. Хүүгийн бус орлогын хувьд шимтгэл хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 21%-р өссөн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад валютын ханш тогтвортой байсантай холбоотой арилжааны ашиг 47%-р буурч 40.1 тэрбум төгрөгт хүрэв. Зардлын хяналтыг хэрэгжүүлснээр, үйл ажиллагааны цэвэр ашиг своп алдагдлыг хасаж тооцвол 6%-р өсөж 275.5 тэрбум төгрөгт хүрсэн ба своп алдагдлыг оруулбал 10%-р буурч 190.1 тэрбум төгрөгт хүрэв.

Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр сангийн зардал өмнөх оны мөн үеэс 76%-р буурч 25.6 тэрбум төгрөгт хүрэв. 2023 оны 3-р улирлын эцсийн байдлаар цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 66%-р өсөж 130.4 тэрбум хүрээд байна. Цэвэр хүүгийн ахиуц харьцаа 2022 оны эцэст 5.7% байсан бол 6.3%-д хүрч сайжрав. Өөрийн хөрөнгийн өгөөж 20.1%-д хүрлээ.

Зах зээл дээрх хүүгийн түвшин 2023 оны сүүлийн улиралд ч өндөр хэвээр үргэлжлэх төлөвтэй байгаа тул хүүгийн орлого өсөх хандлагатай байгаа бол зээлийн хүү болон валютын ханшийн хэлбэлзэл тогтвортой байх тул СВОП-н үнэ цэний хэлбэлзэл болон зээлийн сангийн зардал бага байх төлөвтэй байна. Банкны 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг 140 тэрбум төгрөгөөс давах төлөвтэй байна.

**2023 оны 8-р сарын эцсээр*

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ 2023'08



Арилжааны хэмжээ
26%

Онлайн худалдааны
гүйлгээний тоо, дүн
68%, 45%

Н1'2023 байдлаар

Кастодиан банкны
харилцагчийн тоо
44%



Орон сууцны зээл
24%

Кредит карт
44%

Аккредитивын хэмжээ
63%


Балансын гүйцэтгэл Q3'2023

Балансын үзүүлэлт (тэрбум ₮)	2022Q3	2022Q4	2023Q3	YTD	%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,997	2,238	2,701	463	21%
Банк санхүүгын байгууллагад байршуулсан хөрөнгө	1,365	1,439	1,153	(285)	-20%
Хөрөнгө оруулалт	539	699	838	139	20%
Цэвэр зээл	3,674	3,608	4,095	487	14%
Үндсэн хөрөнгө	383	385	510	125	32%
Бусад актив	509	556	350	(206)	-37%
Нийт хөрөнгө	8,467	8,925	9,648	723	8%
Харилцагчдын эх үүсвэр	5,527	5,620	6,749	1,129	20%
Харилцах	2,443	2,703	3,347	644	24%
Хадгаламж	3,084	2,917	3,402	485	17%
Банк санхүүгын байгууллагаас татсан эх үүсвэр	1,825	1,999	1,598	(401)	-20%
Бусад эх үүсвэр	304	306	253	(53)	-17%
Бусад өр төлбөр	106	156	151	(5)	-3%
Нийт өр төлбөр	7,762	8,082	8,751	670	8%
Нийт өөрийн хөрөнгө	705	844	897	53	6%
Чанаргүй зээлийн харьцаа	7.6%	6.9%	6.1%		
Эрсдэлийн хүрэлцээний харьцаа	70.6%	96.4%	101.4%		
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа	14.2%	17.7%	16.4%		
ТТГЧ-ын харьцаа	34.7%	36.3%	39.0%		

Балансын гүйцэтгэл

- Харилцагчдын эх үүсвэр өнгөрсөн оны эцсээс 1.1 их наяд төгрөгөөр /20%/ өсөж 6.7 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 68%-г Корпорэйт сегмент, 19%-г Ритэйл сегмент, үлдсэн 13%-г ЖДБ сегмент бүрдүүлж байна.
- Цэвэр зээл 487 тэрбум төгрөгөөр /14%/ өсөж 4.1 их наяд төгрөгт хүрэв. Нийт өсөлтийн 65%-г Ритэйл зээлийн өсөлт бүрдүүлж байна.
- Банк 4-р сард нэгж хувьцаанд 50 төгрөг буюу нийт 40.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараав /DPR=40%/.

Сегментийн бүтэц (%) *



* Дотоод сегментийн бодлогын дагуу



ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ Q3'2023

Орлогын тайлан (тэрбум ₮)	2022Q3	2022Q4	2023Q3	ҮоҮ	%
Хүүгийн орлого	480.9	669.5	704.8	223.8	47%
Хүүгийн зардал	218.5	307.9	370.0	151.5	69%
Цэвэр хүүгийн орлого	262.4	361.6	334.8	72.4	28%
Цэвэр хүүгийн бус орлого	65.1	150.9	(4.3)	(69.4)	-107%
Шимтгэл хураамжийн орлого	62.5	85.1	75.8	13.3	21%
Цэвэр арилжааны ашиг	26.7	100.4	(45.2)	(71.9)	-269%
Арилжааны ашиг	75.4	106.0	40.1	(35.2)	-47%
СВОП-ын нөлөө	(48.6)	(5.6)	(85.3)	(36.7)	75%
Бусад хүүгийн бус орлого	16.1	20.5	9.4	(6.7)	-42%
Хүүгийн бус зардал	40.3	55.1	44.4	4.1	10%
Үйл ажиллагааны орлого	327.5	512.5	330.4	2.9	1%
Үйл ажиллагааны орлого /СВОП-гүй/	376.1	518.1	415.8	39.6	11%
Үйл ажиллагааны зардал	115.6	165.9	140.3	24.7	21%
Үйл ажиллагааны ашиг	211.9	346.6	190.1	(21.8)	-10%
Үйл ажиллагааны ашиг /СВОП-гүй/	260.5	352.2	275.5	14.9	6%
Эрсдэлийн сангийн зардал	105.7	192.6	25.6	(80.1)	-76%
Татварын өмнөх ашиг	106.2	154.0	164.5	58.3	55%
Татварын зардал	27.7	53.5	34.1	6.3	23%
Цэвэр ашиг	78.5	100.5	130.4	52.0	66%
Цэвэр хүүгийн ахиуц*	5.5%	5.7%	6.3%		
Зардал орлогын харьцаа /СВОП-гүй/	30.7%	32.0%	33.7%		
Өөрийн хөрөнгийн өгөөж	15.8%	14.4%	20.1%		
Нийт хөрөнгийн өгөөж	1.3%	1.2%	1.9%		

* Дотоод аргачлал

Ашигт ажиллагааны гүйцэтгэл:

- Цэвэр хүүгийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 28% өсөж 334.8 тэрбум төгрөгт хүрэв.
- Цэвэр хүүгийн бус орлогын хувьд сөрөг -4.3 тэрбум төгрөг гарсан бөгөөд хэрэв СВОП нөлөө -85.3 тэрбум төгрөгийн алдагдлыг хасаж тооцвол 81 тэрбум төгрөгийн цэвэр орлоготой ажиллав.
 - Шимтгэл хураамжийн орлого 21%-р өсөж 75.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.
 - Зах зээлийн нөхцөл байдлын нөлөөгөөр арилжааны ашиг өнгөрсөн оны мөн үеэс 47%-р буурч 40.1 тэрбум төгрөгт хүрэв.
 - Мөн зах зээлийн нөхцөл өмнөх жилээс өөрчлөлттэй холбоотой СВОП хэлцлийн нөлөө -85.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байв.
- Сангийн зардлын өмнөх цэвэр үйл ажиллагааны ашиг 10%-р буурч 190.1 тэрбум төгрөгт хүрэв. Хэрэв СВОП нөлөөг хасаж тооцвол үйл ажиллагааны ашиг 6%-р өсөж 275.5 тэрбум төгрөгт хүрсэн үр дүнтэй байлаа.
- Цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс 66%-р өсөж 130.4 төгрөгт хүрэв.
- Ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтүүдээр өнгөрсөн оны мөн үеэс сайжирсан үр дүнтэй байна.
- Энэ хугацаанд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллав.


СВОП хэлцлийн нөлөө:

Зах зээлийн нөхцөл байдлын нөлөөгөөр СВОП хэлцэл дээр -85.3 тэрбум төгрөгийн үнэ цэний алдагдал бүртгэгдээд байна.




АШИГТ АЖИЛЛАГАА Q3'2023

Цэвэр үйл ажиллагааны ашиг (СВОП-гүй) Сегментийн бүтэц



Улирлын цэвэр ашиг (тэрбум ₮)



Улирлын цэвэр ашгийн өсөлт 2022/2023


1Q2023/1Q2022 +47.6%

2Q2023/2Q2022 +29.2%


3Q2023/3Q2022 +146.7%

Г САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ /СТОУС-ын дагуу/

Санхүүгийн зорилт 2023, ҮЦ-ны танилцуулгаар /тэрбум ₮/



Цэвэр ашиг /тэрбум ₮/ болон Өөрийн хөрөнгийн өгөөж /%/



АНХААРУУЛГА

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрддөг бол Арилжааны банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг дагаж мөрддөг. Энэхүү журамд 2017 оноос хойш шинэчлэгдсэн зарим стандарт (СТОУС-9, СТОУС-15, СТОУС-16 гэх мэт)-ын өөрчлөлтийг тусгаагүй байдаг. Иймд дээрх журмын дагуу бэлтгэн улирал бүр олон нийтэд мэдээлж буй тайлан нь Банкны СТОУС-т нийцсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй байж болох ба зээл, эх үүсвэр, ашигт ажиллагааны сегментийн бүтцийг банкны дотоод аргачлалд тулгуурласан болно. Энэхүү баримт бичигт дурьдагдсан аливаа санхүүгийн төсөөлөл, хүлээлт, таамаглал зэрэг мэдээллүүд нь өнгөрсөн үеийн тайлан, компанийн үнэлгээ, итгэл үнэмшил болон зах зээлийн бусад хүчин зүйлсэд үндэслэсэн тул урьдчилан таамаглаагүй, гэнэтийн эрсдэл, тодорхойгүй нөхцөл байдлын улмаас бодит үр дүн дээрх таамаглалаас өөр буюу зөрүүтэй байж болно. Тиймээс уг таамаглал нь ирээдүйд бий болох аливаа гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд үүнд хүлээлт үүсгэж, найдлага тавьж болохгүй.

Анхаарал тавьсанд баярлалаа